

## НИСЭХИЙН СУРГАЛТЫН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2021.09.06

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын баталсан 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн “Нисэхийн сургалтын төвийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай” 11/21 тоот удирдамжийн хүрээнд ээлжит дотоод аудит, хяналт шалгалт хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны ахлах аудитор Л.Жаргалсайхан, аудитор А.Мөнх-Эрдэнэ, Т.Саранчимэг, О.Сэндэр, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Ж.Нямдэлгэр, Ж.Энэрэл нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2021 оны 07 дугаар сарын 22-ны өдрөөс 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийг дуустал хугацаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Нисэхийн сургалтын төвийн 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацааны архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, анхан шатны баримт бүрдүүлэлт, төлөвлөгөөний хэрэгжилт, цалин хөлсний бодолт, олголт, багшилсан цагийн тооцоо, дотоод сургалтын төлөвлөлт, хэрэгжилт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Нисэхийн сургалтын төв нь Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8.-д заасан мэргэжлийн сургалтын “Тусгай зөвшөөрөл” аваагүй, мэргэшлийн сургалт явуулах “Мэргэжлийн сургалтын байгууллагын бүртгэлийн гэрчилгээ”-ний хүчинтэй хугацаа дууссан.

ИНЕГ, ИНҮТ-ийн захиргааны асуудал эрхэлсэн нэгжүүд нь Иргэний нисэхийн ажил мэргэжлүүдийг “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт 08” буюу YAMAT-д бүртгүүлэх тал дээр анхаараагүй, Нисэхийн сургалтын төв нь дээд байгууллага, удирдлагууддаа хандан идэвхтэй ажиллаагүйгээс өнөөдрийг хүртэл мэргэжлийн сургалтын байгууллагын гэрчилгээгээ сунгуулаагүй, иргэний нисэхийн ажил мэргэжлүүдийг “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт 08”-д оруулах ажил удаашралтай явагдаж байна.

Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлгүй, мэргэжлийн сургалтын байгууллагын бүртгэлийн гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан тул Нисэхийн сургалтын төвөөс явуулж байгаа мэргэжлийн болон мэргэшлийн давтан сургалтууд хүчин төгөлдөр бусд тооцогдохоор болсон байна.

НААХЗА-ын Үнэмлэх, гэрчилгээжүүлэлтийн хэлтсээс Нисэхийн сургалтын төвд ИНД 141-ийн дагуу гэрчилгээ олгох үйл явц нь Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн холбогдох заалтуудтай зөрчилдөж байгааг уялдуулах шаардлагатай.

Албан бичиг боловсруулалт, түүний бүртгэл, хөтлөлтийн байдал хангалтгүй, “Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ыг мөрдлөг болгон ажилладаггүй, боловсруулсан баримт бичиг нь үг, үсгийн алдаа ихтэй, утга найруулга муутай байна.

Хариутай албан бичгийн хариуцан шийдвэрлэх ажилтны нэр, хэрэгжүүлэх хугацаа, цохолт хийсэн огноог бичээгүй, ирсэн бичгийн шийдвэрлэлтийн талаар хариуцсан ажилтан нь бүртгэл-хяналтын картанд тэмдэглэл хийгээгүй.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн багшлагч мэргэжилтнүүд нь журамд заасан тус чиглэлээр хичээл заах багшид тавигдах шаардлагыг хангахгүй, багшлагч мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг боловсруулахдаа ажилтанд нийцүүлж боловсруулсан.

2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр батлагдсан “Trainair Plus хөтөлбөрийн хүрээнд олон улсын сургалт зохион байгуулах журам”-ын 2.2.1.-д заасан 3 жил тутамд хамгийн багадаа нэг STP боловсруулсан байх шаардлага биелээгүй. НСТ-ийн удирдлага болон хөтөлбөр хариуцсан ажилтнууд санаачилгагүй, хангалтгүй түвшинд ажиллаж байна.

Нисэхийн сургалтын төвөөс ICAO-ын Trainair Plus хөтөлбөрийн хүрээнд 2020 онд хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны төлөвлөгөөгөө 78 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байсныг аудитор хянаж үзээд 67 хувьтай буюу хэрэгжилт хангалтгүй, 2021 оны эхний хагас жилийн байдлаар гүйцэтгэхээр тусгасан 4 үйл ажиллагааны биелэлт хангалтгүй байна.

Албан тушаалын тодорхойлолтоор заагдсан ажлын чиг үүрэг бүхий хариуцсан ажилтнууд хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцохгүй, идэвх санаачилгагүй байгаагаас тус хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй үзүүлэлттэй байна.

Сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа заавар, журмыг мөрдөж ажиллаагүй, багш нарын заах арга зүй, багшлах ур чадвар дутмагаас суралцагч нар сургалтдаа сэтгэл ханамжгүй байна.

Ажилтнууд албан тушаалын тодорхойлолтод заагдсан үндсэн зорилтоо хэрэгжүүлэх ажлаа хийсний төлөө нэмэгдэл хөлс авсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, заавар, журмыг мөрдөж ажиллаагүйн улмаас сургалт явуулсан багшийн цагийн тооцоонд хяналт тавьдаггүйгээс үндсэн болон гэрээт багш нарт нэмэгдэл хөлс илүү олгосон.

Нисэхийн сургалтын төвийн өөрийн ажилтнууд шалгалт авсан болон багшилсан цагийн нэмэгдэл хөлс авсан нь хөдөлмөрийн дотоод журмын заалтыг зөрчсөн.

Үндсэн болон гэрээт багшлагч мэргэжилтнүүд нь “Үйл ажиллагааны ерөнхий заавар”-т заасан шаардлагад нийцэхгүй байгаа нь заавар, журмаа мөрдөж ажилладаггүй, сонгон шалгаруулалт хийдэггүйтэй холбоотой байна.

Бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор цалин хөлсний нягтлан бодогч солигдсоноос өмнөх аудитын зөвлөмжөөр өгөгдсөн суутгал хийгдээгүй байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтнуудын ажлын хариуцлага сул, мэргэжлийн ур чадвар дутмагаас хяналт шалгалтын ажил үр дүн муутай, үнэлэлт дүгнэлт гаргадаггүй, зөвлөмж өгдөггүй, эргэн хяналт тавьдаггүй байна. Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын DOC 9841 Сургалтын байгууллагуудын заавар (Manual on the Approval of Training Organizations)-ын Appendix B-д заасан Нисэхийн сургалтын байгууллагын дотоод хяналтын ажилтны чиг үүргийг тус төвийн Дотоод хяналт, чанарын удирдлагын ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтын зорилт хэсэгт бүрэн оруулаагүй. Дотоод хяналтын ажилтны мэргэжлийн мэдлэг, ур чадвар дутмаг байна.

НСТ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/505, А/267 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтаар “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдөд мэргэжлийн диплом, үнэмлэх, гэрчилгээ олгох журам”-д заасны дагуу төгсөгчдөд гэрчилгээ олгодоггүй, сургалтаа мэргэжлийн болон мэргэшлийн түвшин ахиулах сургалтаар ангилан төрөлжүүлээгүй байна.

Сургалт, заах арга зүйн ахлах мэргэжилтэн сургалтын төлөвлөгөө боловсруулахдаа жил бүрийн сургалтын хэрэгцээг шаардлагыг тодорхойлдоггүй, тооцоо, судалгаа хийдэггүй, зөвхөн харьяа алба, салбар, нэгжүүдээс ирүүлсэн албан бичгүүдийг нэгтгэх хэмжээнд ажиллаж байна.

Сургалт хариуцсан мэргэжилтнүүд сургалтын үр дүн, хэрэгцээ шаардлагад дүн шинжилгээ хийдэггүй, дотоод хяналт хариуцсан ажилтан хяналт тавьж ажилладаггүй.

ИНЕГ-ын даргын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/688 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр үзлэг, гурван шатны хяналтыг зохион байгуулах журам”-ыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй. Гурван шатны хяналтын дэвтрийг үйл ажиллагаандаа ашигладаггүй, хяналт тавьдаггүй.

Сургалтад хамруулах тухай тушаалын хавсралтад заагдаагүй суралцагчийг сургалтад хамруулж, гэрчилгээ олгосон, сургалтад хамрагдах ажилтнуудын судалгаа гаргадаггүй, хичээл заасан багш суралцагчдын ирцийн бүртгэл болон сургалтын журналыг дутуу хөтөлдөг, сургалт хариуцсан мэргэжилтэн шалгалтыг зааврын дагуу явуулдаггүй, шалгалтын протокол хөтөлдөггүй байна.

Музейг сурталчлан таниулах зорилгоор олон үр бүтээлтэй томоохон арга хэмжээ зохион байгуулах шаардлагатай ч үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа судалгаа хийгээгүй, өдөр тутмын ажил тусгасан, түүнийг хянан баталгаажуулсан удирдах ажилтнуудын хяналт сул байна. Нисэх хүчний 90 гаруй жилийн түүх, соёлыг хариуцлагатайгаар хадгалах үүрэгтэй нэгжийн үйл ажиллагаа нь зохион байгуулалтгүй, идэвх санаачилгагүй, сан хөмрөг нэмэгдүүлэх, судалгаа хийх зэрэг ажлыг хангалттай түвшинд зохион байгуулахгүй байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлыг арилгах, залруулах талаар Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт зохицуулалтын албанд 1, Иргэний нисэхийн үндэсний төвд 5, Нисэхийн сургалтын төвд 14, нийт 20 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА